



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур дүүргийн Прокурорын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/392/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarhk@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Н.Бадамхатан Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 56
танай _____-ны № _____-Т

БАГАНУУР ДҮҮРГИЙН
ПРОКУРОРЫН ГАЗРЫН
ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Н.ГАНТОГТОХ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Багануур дүүргийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Багануур дүүргийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

002021637

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 100.0 хувийн хэрэгжилттэйгээр гүйцэтгэн, тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,407,494.00	43,555,005.00
33	АВЛАГА	-	4,394,790.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	3,568,000.00
335	Бусад авлага	-	826,790.00
3351	Байгууллагаас авах авлага	-	826,790.00
35	БАРАА МАТЕРИАЛ	31,407,494.00	39,160,215.00
354	Хангамжийн материал	31,407,494.00	39,160,215.00
35410	Бичиг хэргийн материал	1,917,702.00	5,255,617.00
35420	Аж ахуйн материал	-	634,500.00
35440	Түлш, шатах тослох материал	260,000.00	-
35450	Барилгын засварын материал	-	1,303,500.00
35460	Хүнсний материал	-	19,699.00
35470	Бусад хангамжийн материал	29,229,792.00	31,946,899.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	458,723,376.03	3,096,646,796.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	458,723,376.03	3,096,646,796.53
392	Биет хөрөнгө	366,836,709.34	3,004,860,129.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	162,223,176.60	2,833,291,801.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,180,618.40)	(27,331,116.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	46,950,000.00	46,950,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,495,833.33)	(22,614,583.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,482,275.05	164,967,337.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,967,496.77)	(67,455,350.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,278,070.33	91,330,970.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,397,308.58)	(18,890,040.69)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,000,000.00	5,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(55,555.56)	(388,888.92)
393	Биет бус хөрөнгө	91,886,666.69	91,786,666.73
39301	Программ хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(58,333.31)	(158,333.27)
39303	Бусад биет бус хөрөнгө	91,545,000.00	91,545,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	490,130,870.03	3,140,201,801.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	1,000,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,000,000.00
413	Өглөг	-	1,000,000.00
4136	Бусад өглөг	-	1,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	490,130,870.03	3,139,201,801.53
51	Засгийн газрын хувь оролцоо	490,130,870.03	3,139,201,801.53

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	218,355,315.75	218,355,315.75
51101	Өмч: - төрийн	218,355,315.75	218,355,315.75
512	Хуримтлагдсан үр дүн	237,446,192.65	2,886,517,124.15
51210	Өмнөх үеийн үр дүн	237,446,192.65	237,446,192.65
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,649,070,931.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,329,361.63	34,329,361.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>490,130,870.03</u>	<u>3,140,201,801.53</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	840,527,070.00	3,568,470,435.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,281,970.00	2,689,378,235.00
120	Нийтлэг татварын бус орлого	84,281,970.00	2,689,378,235.00
120045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	84,284,970.00	2,689,378,235.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	756,245,100.00	879,092,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	746,245,100.00	879,092,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	746,245,100.00	879,092,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	785,237,326.50	919,399,503.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	785,237,326.50	919,399,503.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	709,465,875.76	816,115,974.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	493,925,485.00	553,865,194.50
210101	Үндсэн цалин	316,235,186.00	343,712,213.01
210102	Нэмэгдэл	117,723,720.00	117,073,921.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,053,705.00	34,854,117.65
210104	Урамшуулал	25,492,874.00	51,624,941.47
210105	Гэрээт ажлын хөлс	420,000.00	6,600,001.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,313,713.18	68,738,446.55
210201	Тэтгэврийн даатгал	45,194,838.92	46,901,819.61
210202	Тэтгэмжийн даатгал	4,812,084.52	5,507,831.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,832,867.66	4,357,865.42
210204	Ажилгүйдлийн даатгал	950,211.06	1,076,266.36
210205	Эрүүл мэндийн даатгал	9,523,711.02	10,894,663.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,940,844.90	42,034,510.30
210301	Гэрэл, цахилгаан	2,943,627.59	4,113,860.49
210302	Түлш, халаалт	8,152,239.28	22,810,930.08
210303	Цэвэр, бохир ус	5,720,228.03	15,109,719.73
210304	Байрны түрээс	11,124,750.00	-

2104	Хангамж, бараа материалын зардал	44,588,465.18	33,586,911.95
210401	Бичиг хэрэг	17,111,511.00	12,640,720.90
210402	Тээвэр, шатахуун	10,191,400.00	7,885,659.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,845,588.18	3,957,137.34
210404	Ном, хэвлэл	74,897.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,079,919.00	688,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,724,150.00	8,414,494.71
210408	Бараа материал акталсны зардал	3,561,000.00	-
2105	Нормативт зардал	-	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,125,980.00	23,323,195.00
210604	Урсгал засвар	9,125,980.00	23,323,195.00
2107	Томилолт, зочны зардал	1,052,000.00	5,624,000.00
210702	Дотоод албан томилолт	1,052,000.00	5,624,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,183,809.00	3,275,901.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,653,784.00	2,673,941.30
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240,705.00	240,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	223,320.00	295,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,335,578.50	84,667,814.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,356,540.00	12,683,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,040,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,939,038.50	71,984,714.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,771,450.74	103,283,529.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,743,000.00	49,150,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	45,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,743,000.00	3,650,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	73,028,450.74	54,133,529.40
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,028,450.74	54,133,529.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>55,289,743.50</u>	<u>2,649,070,931.50</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	361,250.00	-
225009	Дамжуулан зээлдүүлэх зээл	361,250.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(361,250.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>54,928,493.50</u>	<u>2,649,070,931.50</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>756,245,100.00</u>	<u>879,092,200.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	756,245,100.00	879,092,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	746,245,100.00	879,092,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	746,245,100.00	879,092,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>723,710,100.00</u>	<u>858,562,300.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	723,710,100.00	858,562,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	647,938,649.26	755,278,770.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	498,217,605.00	556,433,194.50
210101	Үндсэн цалин	320,064,306.00	343,712,213.01
210102	Нэмэгдэл	118,186,720.00	117,073,921.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,053,705.00	38,422,117.65
210104	Урамшуулал	25,492,874.00	50,624,941.47
210105	Гэрээт ажлын хөлс	420,000.00	6,600,001.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,021,593.18	68,738,446.55
210201	Тэтгэврийн даатгал	40,902,718.92	46,901,819.61
210202	Тэтгэмжийн даатгал	4,812,084.52	5,507,831.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,832,867.66	4,357,865.42
210204	Ажилгүйдлийн даатгал	950,211.06	1,076,266.36
210205	Эрүүл мэндийн даатгал	9,523,711.02	10,894,663.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,940,844.90	42,034,510.30
210301	Гэрэл, цахилгаан	2,943,627.59	4,113,860.49
210302	Түлш, халаалт	8,152,239.28	22,810,930.08
210303	Цэвэр, бохир ус	5,720,228.03	15,109,719.73
210304	Байрны түрээс	11,124,750.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	35,732,891.18	46,132,617.95
210401	Бичиг хэрэг	11,481,854.00	17,488,589.90
210402	Тээвэр, шатахуун	10,451,400.00	8,452,449.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,845,588.18	5,257,137.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,229,880.00	688,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,724,169.00	14,245,541.71
2105	Нормативт зардал	1,500,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,225,980.00	12,622,500.00
210604	Урсгал засвар	4,225,980.00	12,622,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,052,000.00	5,624,000.00
210702	Дотоод албан томилолт	1,052,000.00	5,624,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,033,565.00	5,395,901.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,503,540.00	4,793,941.30
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240,705.00	240,700.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	223,320.00	295,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,214,170.00	18,297,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,214,170.00	18,297,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,771,450.74	103,283,529.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,743,000.00	49,150,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	45,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,743,000.00	3,650,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	73,028,450.74	54,133,529.40
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,028,450.74	54,133,529.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>32,535,000.00</u>	<u>20,529,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	32,535,000.00	20,529,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,535,000.00	20,529,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	32,535,000.00	20,529,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	32,535,000.00	20,529,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(32,535,000.00)</u>	<u>(20,529,900.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	218,355,315.75	34,561,078.22	182,285,982.11	435,202,376.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	231,716.59	231,716.59
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,355,315.75	34,561,078.22	182,517,698.70	435,434,092.67
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	54,928,493.50	54,928,493.50
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,355,315.75	34,329,361.63	237,446,192.65	490,130,870.03

2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	218,355,315.75	34,329,361.63	237,446,192.65	490,130,870.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,355,315.75	34,329,361.63	237,446,192.65	490,130,870.03
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,649,070,931.50	2,649,070,931.50
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,355,315.75	34,329,361.63	2,886,517,124.15	3,139,201,801.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	879,092,200.00	824,958,670.60	54,133,529.40	94%
УРСГАЛ ЗАРДАЛ	879,092,200.00	824,958,670.60	54,133,529.40	94%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	829,892,200.00	775,808,670.60	54,083,529.40	93%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	598,621,600.00	556,433,194.50	42,188,405.50	93%
Үндсэн цалин	350,535,600.00	343,712,213.01	6,823,386.99	98%
Нэмэгдэл	197,127,600.00	117,073,921.37	80,053,678.63	59%
Унаа хоолны хөнгөлөлт	40,958,400.00	38,422,117.65	2,536,282.35	94%
Урамшуулал	10,000,000.00	50,624,941.47	(40,624,941.47)	506%
Гэрээт ажлын хөлс	-	6,600,001.00	(6,600,001.00)	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,827,600.00	68,738,446.55	6,089,153.45	92%
Тэтгэврийн даатгал	50,882,800.00	46,901,819.61	3,980,980.39	92%
Тэтгэмжийн даатгал	5,986,200.00	5,507,831.68	478,368.32	92%
ҮОМШӨ-ний даатгал	4,789,000.00	4,357,865.42	431,134.58	91%
Ажилгүйдлийн даатгал	1,197,200.00	1,076,266.36	120,933.64	90%
Эрүүл мэндийн даатгал	11,972,400.00	10,894,663.48	1,077,736.52	91%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,591,400.00	42,034,510.30	4,556,889.70	90%
Гэрэл, цахилгаан	5,280,000.00	4,113,860.49	1,166,139.51	78%
Түлш, халаалт	25,411,400.00	22,810,930.08	2,600,469.92	90%
Цэвэр, бохир ус	15,900,000.00	15,109,719.73	790,280.27	95%

Хангамж, бараа материалын зардал	46,808,700.00	46,662,517.95	146,182.05	100%
Бичиг хэрэг	17,500,000.00	17,488,589.90	11,410.10	100%
Тээвэр, шатахуун	8,648,700.00	8,452,449.00	196,251.00	98%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,500,000.00	5,257,137.34	242,862.66	96%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	688,900.00	(328,900.00)	191%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,800,000.00	14,775,441.71	24,558.29	100%
Эд хогшил, урсгал засварын зардал	32,635,000.00	32,622,500.00	12,500.00	100%
Тавилга	20,000,000.00	20,000,000.00	-	100%
Урсгал засвар	12,635,000.00	12,622,500.00	12,500.00	100%
Томилолт, зочны зардал	6,550,000.00	5,624,000.00	926,000.00	86%
Дотоод албан томилолт	6,550,000.00	5,624,000.00	926,000.00	86%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,560,300.00	5,395,901.30	164,398.70	97%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,794,000.00	4,793,941.30	58.70	100%
Тээврийн хэрэгслийн татвар	405,000.00	240,700.00	164,300.00	59%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00	-	100%
Газрын төлбөр	295,300.00	295,260.00	40.00	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	18,297,600.00	18,297,600.00	-	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	18,297,600.00	18,297,600.00	-	100%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,200,000.00	49,150,000.00	50,000.00	100%
Бусад урсгал шилжүүлэг	49,200,000.00	49,150,000.00	50,000.00	100%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,500,000.00	45,500,000.00	-	100%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,700,000.00	3,650,000.00	50,000.00	99%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	879,092,200.00	824,958,670.60	54,133,529.40	94%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	879,092,200.00	824,958,670.60	54,133,529.40	94%
Улсын төсвөөс санхүүжих	879,092,200.00	824,958,670.60	54,133,529.40	94%
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			-	
АЖИЛЛАГСДЫН ТОО	23	23	-	100%
Удирдах ажилтан	1	1	-	100%
Гүйцэтгэх ажилтан	7	7	-	100%
Үйлчлэх ажилтан	15	15	-	100%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 113,465.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс, аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын дансанд ангилал зөрүүтэй хөрөнгө бүртгэсэн.	1	1,828.4			1	1,828.4	1	1,828.4				
Хангамжийн материалыг шууд зардлаар бүртгэсэн	1	6,050.0			1	6,050.0	1	6,050.0				
Цалингаас тооцсон татвар, шимтгэлийг цалингийн өглөгөөр дамжуулаагүй	1	105,587.1			1	105,587.1	1	105,587.1				
Дүн	3	113,465.5			3	113,465.5	3	113,465.5				

Аудитаар нийт 11,354.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, алдаа зөрчлийг арилгах 3,160.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 8,194.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бүртгэсэн	1	2,800.0					1	2,800.0				
Санхүүгийн тайлант жилийн эцэст авлага, өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан	1	5,394.8					1	5,394.8				
Прокурорын спортын наадамд оролцсон албан хаагчдын хоол унаа, буудлын	1	3,160.0			1	3,160.0						

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төлбөрийг томилолтын зардлаас гаргасан.												
Дүн	3	11,354.8	-	-	1	3,160.0	2	8,194.8	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Шилэн дансны тухай хуулийн хүрээнд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд орлого, зарлагын гүйлгээг өссөн дүнгээр мэдээлсэн.	1	-					1	-
Дүн	1	-					1	-